

2026 оны 04 сарын 09 өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

**Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн бүтэц, зохион
байгуулалтыг шинэчлэн батлах тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, Банкны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.1 дэх заалт, “Худалдаа, хөгжлийн банк” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.11.2 дахь заалт, Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин, урамшууллын болон нэр дэвшүүлэх хорооны 2026 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. “Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц”-ийг энэхүү тогтоолын хавсралтын дагуу шинэчлэн баталсугай.
2. Энэхүү тогтоолыг 2026 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллах, дотоод зохион байгуулалт хийхийг Гүйцэтгэх захирал (О.Орхон)-д үүрэг болгосугай.
3. Энэхүү бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлттэй холбогдуулан Худалдаа, хөгжлийн банканд мөрдөгдөж буй холбогдох заавар, журмуудад нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэхийг Гүйцэтгэх захирал (О.Орхон)-д даалгасугай.
4. Энэхүү тогтоол мөрдөгдөж эхэлсэн өдрөөс Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 45 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

РАНДОЛФ КОППА

